# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
# ТУШААЛ

2026 оны 04 сарын 27 өдөр Дугаар А/110 Арвайхээр сум

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн томилох,
бэлтгэл ажлын төлөвлөгөө
батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн “Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/87, 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах тухай” А/151 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах, эрүүл мэндийн албаны төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сургуульд оролцох тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар, чиг үүргийг гуравдугаар, бэлтгэл ажлын төлөвлөгөөг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлалсугай.

2.Тушаалын дагуу бэлэн байдлыг хангаж, дадлага сургуулийг сум, орон нутагтаа зохион байгуулж, сургуульд шаардагдах зардлыг төсвийн хүрээнд шийдвэрлэхийг клиник эмнэлгүүд болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ-үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Н.ОЮУНТУЯА

Боловсруулсан
Хянасан

D:\My\Doc.Tushaal. EMG

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 04 сарын 10–ны
өдрийн А/10 р тушаалын нэгдүгээр
хавсралт

КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД
ТОДОТГОЛ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

М.Золзаяа, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
Гишүүд:

Ю.Ичинноров, Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Валя, Эрүүл мэндийн газрын Захиргаа санхүү нийтлэг үйлчилгээний албаны дарга

С.Дуламсүрэн, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Рэгзэдмаа, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн

П.Оюунбилэг, Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн мэргэжилтэн

Д.Нацагням, Эрүүл мэндийн газрын статистикч эмч

Д.Болормаа, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал

Б. Эрдэнэзул, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдлийн менежер

Л.Мэнд-амар, Зоонозын өвчин судлалын төвийн Тархвар судлалын тасгийн эрхлэгч, биологич

Ё.Шүрэнцэцэг, Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 01 дүгээр сарын 27-ны
өдрийн А/10 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

# ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Тохиолдлын удирдлагын тогтолцооны баг нь зохицуулагч, дэд зохицуулагч, холбогч, аюулгүй байдлын бүлэг, эрсдэлийн харилцаа холбооны баг, ажиллагааны баг, төлөвлөлтийн баг, санхүү нөөц, ар талын баг, захиргаа, бичиг хэргийн баг гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

**Зохицуулагч**

Н.Оюунтуяа, Эрүүл мэндийн газрын дарга

**Дэд зохицуулагч, штабын дарга**

М.Золзаяа, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

**Аюулгүй байдлын бүлэг**

Б. Эрдэнэзул, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдлийн менежер

Н.Амаржаргал, Эрүүл мэндийн газрын тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

**Холбогч**

П.Цэнгэлбаяр,Эрүүл мэндийн газрын олон нийттэй харилцах ажилтан

Б.Цэндоо, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдээлэл технологийн инженер

Д.Баярсайхан, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдээлэл технологийн инженер

**Ажиллагааны баг**

Багийн ахлагч:

Ю.Ичинноров, Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Эрхномуун, Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтан

Э.Дуламсүрэн, Эрүүл мэндийн газрын Эх, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Болормаа, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал

Г.Надмидсүрэн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдварын сэргийлэлт хяналтын албаны дарга

Л.Мэнд-Амар, Зоонозын өвчин судлалын төвийн Тархвар судлалын тасгийн эрхлэгч, биологич

Ё.Шүрэнцэцэг, Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

**Төлөвлөлтийн баг**

Багийн ахлагч:

С.Дуламсүрэн, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Д.Нацагням, Эрүүл мэндийн газрын статистикч эмч

Г.Дашжанцан, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга

Б.Сүхбаатар, Зоонозын өвчин судлалын төвийн дарга

Ч.Сэрчмаа, Уянсэтгэл өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

**Хэвлэл мэдээлэл, Эрсдэлийн харилцаа холбооны баг**

Багийн ахлагч:

Ц.Рэгзэдмаа, Эрүүл мэндийн газрын Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Б.Оюунчимэг, Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Д.Аззаяа, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын албаны дарга

С.Цэнддулам, Зоонозын өвчин судлалын төвийн тархвар судлаач эмч

Ш.Мөнхцэцэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан

**Санхүү нөөц, ар талын баг**

Багийн ахлагч:

Б.Валя, Эрүүл мэндийн газрын Захиргаа санхүү нийтлэг үйлчилгээний албаны дарга

Гишүүд:

М.Мөнхбаатар, Эрүүл мэндийн газрын эдийн засагч

Г. Ганчөдөр, Бүсийн оношилгоо эмчилээний төвийн ерөнхий санхүүч

Э.Одбаяр, Эрүүл мэндийн газрын эмийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Ц.Батжаргал, Эрүүл мэндийн газрын нярав

С. Дониддулам, Түшигдэлгээн өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

**Захиргаа, бичиг хэргийн баг**

Багийн ахлагч:

Ж.Болзол, Эрүүл мэндийн газрын удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

П.Оюунбилэг, Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн мэргэжилтэн

Б.Одонтуяа, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөцийн албаны дарга

Ц.Энхтайван, Эрүүл мэндийн газрын архив, бичиг хэргийн ажилтан

С.Шинэхүү, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн архив, бичиг хэргийн ажилтан

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 04 дүгээр сарын 10-ны
өдрийн А/10 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

ЧИГ ҮҮРЭГ

**Хэвлэл мэдээлэл, эрсдэлийн харилцаа холбооны баг**

Хэвлэлийн мэдээлэл, хурал
Мэдээлэл сурталчилгаа
Судалгаа, зар сурталчилгаа
Хариу арга хэмжээний сайн туршлага түгээх

**Аюулгүй байдлын бүлэг**

Штабын аюулгүй байдал
Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй
Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

**Холбогч**

Шуурхай үнэн зөв мэдээлэл дамжуулах
Мэдээллийн аюулгүй байдал
Мэдээллийн зөрчилгүй байдал

**Ажиллагааны баг**

Мэдээлэл солилцоо

Нөхцөл байдлын мэдээллийг штабын даргад мэдээлэх

Тандалт, тархвар зүй

Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Яаралтай тусламжийн баг

Лабораторийн тусламж үйлчилгээ

Хариу арга хэмжээ

Халдварын сэргийлэлт хяналт

Дархлаажуулалт г.м

**Төлөвлөлтийн баг**

Эрсдэлийн үнэлгээ, цаашдын стратеги төлөвлөлт

Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах

Дүн шинжилгээ, эхний төлөв байдал

Нөөцийн бэлэн байдлын төлөвлөлт

Дайчлах хүч хэрэгслийн төлөвлөлт

Ажлын зураг гаргах

Шаардлагатай эрх зүйн орчин бүрдүүлэх г.м

**Санхүү, нөөц, ар талын баг**

Нөөцийн бэлэн байдлын судалгаа

Хүний нөөц

Хамгаалах хувцас хэрэгсэл

Санхүүжилтийн нөөц

Зардлын тооцоо

Нөхөн төлбөр

Худалдан авалт

Бие бүрэлдэхүүний хоол хүнс, хувцас хэрэгслийн зохицуулалт

Цалин, урамшуулал, илүү цаг

Нөөцийн хуваарилалт, тээвэрлэлт, нийлүүлэлт г.м

**Захиргаа, бичиг хэргийн баг**

Бичиг хэрэг

Архив

Эрх зүйн баримт бичгийн хяналт, хуулийн үндэслэл

Хүний нөөцийн ажил амралтын зохицуулалт

Олон улсын байгууллагын хамтын ажиллагаа

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 04 дүгээр сарын 27-ны
өдрийн А/10 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ "КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ"
ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах | Хамтрах | Хяналт тавих |
|---|---|---|---|---|---|
| Нэг. Гамшгаас хамгаалах "Команд штабын сургууль"-ийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд: | | | | | |
| 1.1. | Байгууллага, харьяа байгууллага, албан хаагчдад Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журам, зааврыг танилцуулах, чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх; | 2026 оны 05-р сарын 01-ны дотор | Ж.Болзол, УТХ-ийн дарга | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Эрүүл мэндийн газрын дарга |
| 1.2. | Гамшгаас хамгаалах "Команд штабын сургууль"-ийн бэлтгэл хангахад чиглэсэн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэх хугацаа, хариуцах болон хянах албан тушаалтныг тодорхой томилсон нарийвчилсан төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн дотор баталж, хэрэгжилтэд хяналт тавих; | 2026 оны 04-р сарын 27-ны дотор | Ц.Рэгзэдмаа, НЭМХ-ийн мэргэжилтэн | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 1.3. | Команд штабын сургуулийн "Тохиолдлын удирдлагын тогтолцоо"-ны бүтэц, чиг үүргийг тодорхойлж, бие бүрэлдэхүүнийг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны | 2026 оны 04-р сарын 27-ны дотор | Ц.Рэгзэдмаа, НЭМХ-ийн мэргэжилтэн | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | өдрийн дотор томилж, баталгаажуулах; | | | | |
| 1.4. | “Команд штабын сургууль”-ийн бодлого-төлөвлөгөө, зохион байгуулалтын зааврын хэрэгжилтийг хангах, тактикийн дуурайлган үзүүлэх дадлага, сургуулийн бэлтгэл болон гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн болон байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсруулахад орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас мэргэжил, аргазүйн дэмжлэг авч хамтран ажиллах; | 2026 оны 05-р сарын 01-ны дотор | Ц.Рэгзэдмаа, НЭМХ-ийн мэргэжилтэн | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 1.5. | “Команд штабын сургууль” зохион байгуулахтай холбоотой зардлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж, бэлтгэл бэлэн байдлын хангах; | 2026 оны 05-р сарын 01-ны дотор | Б.Валя, ЗСНҮА-ны дарга | Санхүү, нөөцийн баг Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Эрүүл мэндийн газрын дарга |
| 1.6. | Команд штабын удирдлагын байрыг бэлтгэх, сургуульд шаардлагатай техник, хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангуулах; | 2026 оны 05-р сарын 11-ны дотор | Б.Оюунчимэг, НЭМХ-ийн мэргэжилтэн<br><br>Э.Дуламсүрэн, ЭТХ-ийн мэргэжилтэн<br><br>М.Ганцэцэг, ХШҮМХ-ийн мэргэжилтэн | Б.Эрдэнэ-Зул, БОЭТ-ийн ХАБ-ын менежер<br><br>Ажлын хэсэг | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга |
| 1.7. | “Команд штабын сургууль”-д оролцох бие бүрэлдэхүүнийг хөдөлмөр хамгааллын хувцас, хүн нэг | 2026 оны 05-р сарын 07-ны дотор | Б.Валя, ЗСНҮА-ны дарга<br><br>Г.Ганчөдөр, БОЭТ-ийн ерөнхий санхүүч | Санхүү, нөөцийн баг<br><br>Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Эрүүл мэндийн газрын дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бүрийн үүргэвчээр хангаж, жигдрүүлэх, хувийн бэлтгэлийг хангуулах; | | | | |
| 1.8. | Зарлан мэдээллийн дохио дамжуулах бүдүүвч, цугларах талбайн зураглал гаргах, холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтанг томилох; | 2026 оны 05-р сарын 07-ны дотор | П.Цэнгэлбаяр, УТХ-ийн ажилтан<br><br>Б.Цэндоо, БОЭТ-ийн МТИ<br><br>Д.Баярсайхан, БОЭТ-ийн МТИ | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 1.9. | Аймгийн онцгой байдлын байгууллагатай хамтран "Яаралтай цуглар" дохиогоор ажиллах сургууль зохион байгуулах талбайг сонгох, бэлэн байдлын үзлэгт хамрагдах бэлтгэл ажлын хүрээнд оролцох хүч хэрэгслийн судалгаа, мэдээллийг бэлтгэх; | 2026 оны 05-р сарын 07-ны дотор | П.Оюунбилэг, УТХ-ийн мэргэжилтэн<br><br>Б.Эрдэнэ-Зул, БОЭТ-ийн ХАБ-ын менежер<br><br>Л.Мэнд-Амар, ЗӨСТ-ийн тархвар судлалын албаны дарга | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 1.10. | Гамшгаас хамгаалах "Команд штабын сургууль"-ийн хугацаанд Эрүүл мэндийн улсын албатай цахимаар холбогдох нөхцөлийг бүрдүүлж, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн инноваци, технологи, цахим хөгжлийн хэлтэст хандан бэлэн байдлыг шалгах. | 2026 оны 05-р сарын 07-ны дотор | П.Цэнгэлбаяр, УТХ-ийн ажилтан<br><br>Б.Цэндоо, БОЭТ-ийн МТИ<br><br>Д.Баярсайхан, БОЭТ-ийн МТИ | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| **Хоёр.Гамшгаас хамгаалах "Команд штабын сургууль" зохион байгуулахтай холбоотой баримт бичиг боловсруулах хүрээнд:** | | | | | |
| 2.1. | Эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн "Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө", | 2026 оны 05-р сарын 01-ны дотор | Ц.Рэгзэдмаа, НЭМХ-ийн мэргэжилтэн<br><br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүн | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулан батлуулах; 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЭМЯ-д хүргүүлэх | | | | |
| 2.2. | Аймгийн Эрүүл мэндийн газар орон нутгийн түвшинд, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд байгууллагын түвшинд хүч хэрэгсэл (барилга, эрүүл мэндийн ажилтан, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад нөөц) дэлгэрэнгүй судалгааг хүргүүлсэн загварын дагуу гаргах; | 2026 оны 05-р сарын 01-ны дотор | Э.Одбаяр, ЭТҮХ-ийн мэргэжилтэн<br><br>Н.Амаржаргал, ЭТҮХ-ийн мэргэжилтэн<br><br>Н.Дунгаамаа, ЭТҮХ-ийн мэргэжилтэн<br><br>П.Оюунбилэг, УТХ-ийн мэргэжилтэн<br><br>М.Мөнхбаатар, эдийн засагч | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга |
| 2.3. | Орон нутгийн хэмжээнд сүүлийн 5-10 жилд тохиолдсон аюулт үзэгдэл, олныг хамарсан ослын судалгаа, мэдээлэл болон байгууллагын түвшинд эрсдэлээ тодорхойлж, дүгнэлт гаргах; | 2026 оны 05-р сарын 05-ны дотор | Д.Нацагням, ХШҮМХ-ийн мэргэжилтэн<br><br>М.Ганцэцэг, ХШҮМХ-ийн мэргэжилтэн<br><br>Ц.Эрхномуун, НЭМХ-ийн мэргэжилтэн<br><br>С.Долгормаа, НЭМХ-ийн мэргэжилтэн | Онцгой байдлын газар,<br><br>Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга |
| 2.4. | Хариу арга хэмжээний төлөвлөлт (хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх) хийх, нүүн шилжих байршил, нэмэлтээр ор | 2026 оны 05-р сарын 01-ны дотор | Ю.Ичинноров, ЭТҮХ-ийн дарга<br><br>М.Золзаяа, НЭМХ-ийн дарга<br><br>С.Дуламсүрэн, НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага<br><br>Төлөвлөлтийн баг | Эрүүл мэндийн газрын дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | дэлгэх, дайчлан гаргах хүч хэрэгслийн судалгааг гарган, дэмжин ажиллах байгууллагыг тодорхойлж, хамтран ажиллах гэрээ байгуулах, дэлгэрэнгүй судалгааг гарган 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЭМЯ-д хүргүүлэх | | Г.Болормаа, БОЭТ-ийн ЭЭО захирал | | |
| 2.5. | Хариу арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай тушаал, шийдвэр, албан бичгийн төслийг боловсруулж бэлэн болгох | 2026 оны 05-р сарын 07-ны дотор | Ж.Болзол, УТХ-ийн дарга<br><br>Б.Ариунзаяат, ХШҮМХ-ийн эмчилгээний чанар хяналтын улсын байцаагч<br><br>Ц.Энхтайван, ЭМГ-ын архив бичиг хэргийн ажилтан<br><br>С.Шинэхүү, БОЭТ-ын архив бичиг хэргийн ажилтан | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| **Гурав. Команд штабын сургуулийн бэлтгэл ажлын мэдээлэл гаргах тайлан мэдээллийг боловсруулах дараах баримт бичгийг заасан хугацаанд Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газарт ирүүлэх:** | | | | | |
| 3.1. | Эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж дүгнэлтийг 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн дотор ЭМЯ-д хүргүүлэх | 2026 оны 05-р сарын 05-ны дотор | Ц.Рэгзэдмаа, НЭМХ-ийн мэргэжилтэн | Ажлын хэсэг, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 3.2. | Сүүлийн 5-10 жилд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсон талаарх видео танилцуулга болон бичмэл тайланг 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн дотор ЭМЯ-д хүргүүлэх | 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн дотор | Б.Оюунчимэг, НЭМХ-ийн мэргэжилтэн<br><br>П.Цэнгэлбаяр, УТХ-ийн мэргэжилтэн | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 3.3. | Гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль”- | 2026 оны 05 дугаар | Б.Оюунчимэг, НЭМХ-ийн мэргэжилтэн | Бүх шатны эрүүл мэндийн | Нийгмийн эрүүл мэндийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зурган болон видео танилцуулга, бичмэл тайланг 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор; | сарын 08-ны өдрийн дотор | П.Цэнгэлбаяр, УТХ-ийн мэргэжилтэн<br><br>Б.Рэнчинхорол, НЭМХ-ийн мэргэжилтэн | байгууллага | хэлтсийн дарга |
| 3.4. | Гамшгаас хамгаалах "Команд штабын сургууль"-ийн тайланг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор | 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор | Ц.Рэгзэдмаа, НЭМХ-ийн мэргэжилтэн<br><br>Ажлын хэсэг | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 3.5. | “Команд штабын сургууль”-ийн үйл ажиллагааны талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан түгээх үйл ажиллагааг зохион байгуулах; | 2026 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд | Б.Оюунчимэг, НЭМХ-ийн мэргэжилтэн<br><br>П.Цэнгэлбаяр, УТХ-ийн мэргэжилтэн | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга |
| 3.6. | “Команд штабын сургууль” зохион байгуулагдах хугацаанд төрийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авах; | 2026 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд | Ю.Ичинноров, ЭТҮХ-ийн дарга<br><br>Г.Дашжанцан, БОЭТ-ийн захирал | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Эрүүл мэндийн газрын дарга |

---oOo---